



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 13 өдөр

Дугаар А/319

Арвайхээр

Үзлэг ангилалт хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3.а, Малын генетик нөөцийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.8.6, 16.8.7, 16.8.8, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 2/01 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “Бүтээлч Өвөрхангай-2020” хөтөлбөрийн 2.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн санхүүжилтээр Баянгол сумын Баянгол омгийн 10000 хонь, Уянга сумын нутгийн 5000 сарлаг, Нарийнтээл сумын Тээлийн улаан нутгийн шилмэл хэвшлийн 10000 ямаа, нийт 3 сумын 25000 толгой малд үзлэг ангилалтын ажлыг 2019 оны 5 дугаар сарын 15-наас 11 дүгээр сарын 15-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Тус сумдын үзлэг ангилалтад хамрагдсан малын ашиг шимийн гарц, чанар, бусад үүлдэр омгийн малаас ялгагдах онцлог шинж, удмын санг хамгаалах, цөм сүрэг бүрдүүлэх, үүнээс хээлтүүлэгч бойжуулах, сайжруулагчаар ашиглах боломжийг судлан шийдвэрлэх, төсөв, хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж, тайланг нэгтгэн холбогдох газарт хүргүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир)-т даалгасугай.

3. Үзлэг ангилалтын ажлыг сум орон нутагтаа зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж, хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Баянгол сумын Засаг дарга (А.Мөнхбат), Нарийнтээл сумын Засаг дарга (Б.Сугар), Уянга сумын Засаг дарга (Б.Доржтогоо) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100670